

ТАНИЛЦУУЛГА /Дэлгэрэнгүй/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын
тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн
төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад Улсын Их Хурал биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлохоор гэж заасан.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “... татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй.” гэж заасан.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг тус хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас хасаж хөнгөлөхөөр заасан бөгөөд үүнд спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг хамаарч байна.

Түүнчлэн Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1. дэх заалтад Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бүрэн эрхийнхээ хүрээнд улсын төсөв болон Спортыг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх спортын төрөл ангиллыг сонгох, үндэсний шигшээ багийг бүрдүүлэхээр заасан байдаг.

Шинэ тутамд эрчимтэй хөгжиж байгаа, ирээдүйд амжилт үзүүлэх боломжтой гэж үзэж болох и-спортын төрөл нь олимпын төрөлд хараахан багтаагүй байх тул дээрх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй байгаа нь спортын энэ төрлийг адил түвшинд авч үзэх боломжгүй байна.

Иймд хуулийн төслийн тандан судалгааны тайлан, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.3 дахь заалтад “Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн үндэсний шигшээ баг, түүний харьяалагддаг спорт холбоо,” гэх агуулгыг нэмэхээр хуулийн төсөл боловсрууллаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Биеийн тамир, спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн и-спортын үндэсний шигшээ баг, түүнд бүртгэлтэй тамирчинд олгосон гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх төрлийн шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлогыг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг нэмэх агуулга бүхий Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу боловсрууллаа.

Хуулийн төсөл санаачлагч